



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

“ӨВ агро гурил тэжээлийн үйлдвэр” ОНӨ ХХК-ийн 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: **ӨВА-2022/10/НА-СТА-ОНА**

Цахим хуудас: www.audit.mn
Улаанбаатар хот
2022 он

Тэргүүлэх аудитор: О.Батжаргал
Утас: 70323253 Цахим хаяг: batjargalo@audit.gov.mn
Аудитын менежер: Д.Гансүх
Утас: 70323833 Цахим хаяг: gansukh.audit@gmail.com
Аудитор: П.Сосорбурам
Утас: 94422277 Цахим хаяг: psosor@yahoo.com
Гэрээгээр гүйцэтгэсэн: Чадварлаг аудит ХХК-ийн
Захирал: Д.Рэнцэнханд
Утас: 99200034 Цахим хаяг: chadvarlagAudit@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт.....	2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан.....	4
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан.....	5
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	6
2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл	6
3. Санхүүгийн тайлангийн тодруулга	Error! Bookmark not defined.
3.1 Байгууллагын үйл ажилагаа	8
3.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин	8
3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого.....	9
4. Аудитын тайлан	8
4.1 Ерөнхий зүйл	Error! Bookmark not defined.
4.2 Дотоод хяналт	Error! Bookmark not defined.
4.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	Error! Bookmark not defined.
4.4 Материаллаг байдал.....	Error! Bookmark not defined.
5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	Error! Bookmark not defined.
5.1 Шилэн дансны мэдээлэл.....	Error! Bookmark not defined.
6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	Error! Bookmark not defined.
7. Дараагийн аудитаар анхаарах асуудал	Error! Bookmark not defined.
8. Аудитын илрүүлэлт.....	Error! Bookmark not defined.
8.1 Залруулсан алдаа	Error! Bookmark not defined.
8.2 Төлбөрийн акт	Error! Bookmark not defined.
8.3 Албан шаардлага	Error! Bookmark not defined.
8.4 Зөвлөмж.....	Error! Bookmark not defined.
9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	Error! Bookmark not defined.

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн удирдлагын ордон, П.Гэндэнгийн гудамж,
5 дугаар баг, Арвайхээр сум, Өвөрхангай аймаг, 62173,
Утас/Факс: (976) 7032 3253,
Цахим шуудан: uvurkhangai@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

2022.05.23 № 342
танай _____-ны № _____-г

ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
"ӨВ АГРО ГУРИЛ ТЭЖЭЭЛИЙН
ҮЙЛДВЭР" ОНӨ ХХК-ИЙН ЗАХИРАЛ
Р.НАМГИЛРАГЧАА ТАНАА

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Өвөрхангай аймгийн Өв агро гурил тэжээлийн үйлдвэр ОНӨ ХХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Өвөрхангай аймгийн Өв агро гурил тэжээлийн үйлдвэр ОНӨ ХХК-ийн 2021 оны оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Тус компани нь тайлант онд хүнсний материал худалдан авсан 3475.7 мянган төгрөгийг бараа материалын тайлан гаргаж, орлого авч зарлага гаргаагүй шууд үйлдвэрлэлийн зардлын дансанд бичсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.4.т " Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна." гэсэн заалтад нийцээгүй, санхүүгийн тайлангийн Эрх ба үүрэг, Иж бүрэн байх, Үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Аудитын гол асуудлууд

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудлууд гэж тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй асуудлууд юм. Санхүүгийн тайланд хийсэн аудитынхаа хүрээнд эдгээр асуудлуудыг нэгтгэсэн байдлаар авч үзсэн ба дүгнэлтээ гаргахдаа эдгээр асуудлуудад тус бүрчлэн дүгнэлт гаргаагүй болно.

015030682

D:\Auditin gazar\baiguullagiin dotood barimt\A4

Бусад мэдээлэл

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



О.БАТЖАРГАЛ

D:\Audiitiin gazar\baiguullagiin dotood barimt\A4

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Мянган төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ХӨРӨНГӨ	-	-
1.1	Эргэлтийн хөрөнгө	-	163,157.2
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө		13,964.8
1.1.2	Дансны авлага		61,764.0
1.1.3	Татвар, НДШ – ийн авлага		
1.1.4	Бусад авлага		
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө	-	-
1.1.6	Бараа материал		87,428.4
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо		
1.1.8	Бусад эргэлтийн хөрөнгө	-	-
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	-	163,157.2
1.2	Эргэлтийн бус хөрөнгө	-	92,593.6
1.2.1	Үндсэн хөрөнгө		92,593.6
1.2.2	Биет бус хөрөнгө		
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	-	92,593.6
1.3	Нийт хөрөнгийн дүн	-	255,750.8
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ	-	-
2.1	ӨР ТӨЛБӨР	-	-
2.1.1	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	79,004.7
2.1.1.1	Дансны өглөг		78,799.1
2.1.1.2	Цалингийн өглөг		
2.1.1.3	Татварын өр		205.6
2.1.1.4	НДШ - ийн өглөг		
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн		
2.1.2	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	-
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	-	-
2.2	Өр төлбөрийн нийт дүн	-	79,004.7
	ЭЗДИЙН ӨМЧ	-	156,686.1
2.3	Өмч	-	20,060.0
2.3.1	-төрийн		20,060.0
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг		-
2.3.9	Хуримтлагдсан ашиг		156,686.1
2.3.11	Эздийн өмчийн дүн	-	176,746.1
2.4	Өр төлбөр ба эздийн өмчийн дүн	-	255,750.8

2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

/мянган төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	Борлуулалтын орлого		151,392.0
2	Борлуулалтын өртөг	-	130,827.7
3	Нийт ашиг (алдагдал)	-	20,564.3
4	Түрээсийн орлого	-	-
5	Хүүний орлого		-
6	Ногдол ашгийн орлого	-	-
7	Эрхийн шимтгэлийн орлого	-	-
8	Бусад орлого		136,370.6
9	Борлуулалт, маркетингийн зардал		10.0
10	Ерөнхий ба удирдлагын зардал		33.2
11	Санхүүгийн зардал	-	-
12	Бусад зардал	-	-
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		-
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	-	-
17	Бусад ашиг (алдагдал)	-	-
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	-	156,891.7
19	Орлогын татварын зардал		205.6
20	Татварын дараахь ашиг (алдагдал)	-	156,686.1
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	-	-
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	156,686.1
23	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-
23.1	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү	-	-
23.2	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-
23.3	Бусад олз (гарз)	-	-
24	Орлогын нийт дүн		
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)	-	-

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/мянган төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Өмч	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
8	2020 оны 12-р сарын 31-ны үлдэгдэл	-	-	-	-
1	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	-
2	Залруулсан үлдэгдэл	-	-	-	-
3	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	-
4	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-
5	Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-	-
6	Зарласан ногдол ашиг	-	-	-	-
7	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	-	-	-
8	2020 оны 12-р сарын 31-ны үлдэгдэл	-	-	-	-
1	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	-
2	Залруулсан үлдэгдэл	-	-	-	-
3	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	156,686.1	156,686.1
4	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-
5	Өмчид гарсан өөрчлөлт	20,060.0	-	-	-
6	Зарласан ногдол ашиг	-	-	-	-
7	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	-	-	-
8	2021 оны 12-р сарын 31-ны үлдэгдэл	20,060.0	-	156,686.1	176,746.1

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/мянган төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	13,964.80
1.1	Мөнгөн орлогын дүн	-	225,998.60
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого		89,628.00
1.1.2	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого		22.00
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого		136,348.60
1.2	Мөнгөн зарлагын дүн	-	212,033.80

1.2.1	Ажиллагчдад төлсөн		27,962.20
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн		8,557.90
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн		173,086.60
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн		
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэг -сэлд төлсөн		
1.2.6	Хүүний төлбөрт төлсөн		
1.2.7	Татварын байгууллагад төлсөн		2,383.90
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн		
1.2.9	Бусад мөнгөн зарлага дүн		43.20
	-норматив зардал		
	-томилолтын зардал		
	-тээврийн хэрэгслийн оношлогоо		
	-бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр х ураамж		43.20
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-	13,964.80
2	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
2.1	Мөнгөн орлогын дүн	-	-
2.1.1	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	-	-
2.1.2	Биет бус хөрөнгө борлуулсны орлого	-	-
2.2	Мөнгөн зарлагын дүн	-	-
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ ний дүн	-	-
3	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
3.1	Мөнгөн орлогын дүн	-	-
3.1.3	Төрөл бүрийн хандив	-	-
3.2	Мөнгөн зарлагын дүн	-	-
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	-	-
3.2.2	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн	-	-
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-	-
4	Валютын ханшийн зөрүү	-	-
4.1	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	-	13,964.80
5	МӨНГӨ, ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГИЙН ЭХНИЙ ҮЛД ЭГДЭЛ	-	-
6	МӨНГӨ, ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГИЙН ЭЦСИЙН ҮЛД ДЭГДЭЛ	-	13,964.80

2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

№	Үзүүлэлт	2020 оны гүйцэтгэл	2021 он			
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Нийт орлого		225,998.6	287,762.6	(61,764.0)	127.3
	Орон нутгийн төсвөөс санхүүжих		196,348.6	136,370.6	59,978.0	69.5
	Өөрийн орлого		29,650.0	151,392.0	(121,742.0)	510.6
2	Нийт зардал		225,999.0	130,870.9	95,128.1	57.9
	Үүнээс :Борлуулалт маркетингийн зардал			10.0	(10.0)	
	Ерөнхий ба удирдлагын зардал			33.2	(33.2)	
3	Татвар төлөхийн өмнөх ашиг		(0.4)	156,891.7	(156,892.1)	
	Татварын зардал		(0.0)	205.6	(205.6)	
4	Ашиг алдагдал			156,686.1	(156,686.1)	
5	Төсвийн нийт төлбөр			2,589.5	(2,589.5)	
6	Төрийн өмчийн ногдол ашиг			-	-	
7	Нийт ажиллагсадын тоо		6.0	5.0	1.0	83.3
8	Цалингийн сан		43,992.6		43,992.6	-
9	Нэг ажилтны дундаж цалин		916.5125		916.5	-
10	Борлуулалтын нэг төгрөгт ногдох зардал				-	
11	Хөрөнгө оруулалт				-	
12	Нийт авлага			61,764.0	(61,764.0)	
13	Нийт өглөг			79,004.7	(79,004.7)	
	Үүнээс богино хугацаат өглөг			79,004.7	(79,004.7)	
	урт хугацаат өглөг				-	

3. Санхүүгийн тайлангийн тодруулга

3.1 Байгууллагын үйл ажиллагаа

“ӨВ агро гурил тэжээлийн үйлдвэр” ОНӨ ХХК-ийн зорилго нь гурил, малын тэжээлийг орон нутагтаа үйлдвэрлэж Аймгийн өвсний нөөцийг хангах, өвсний зах зээлийн үнийг тогтвортой барьж малчдад хямд өвс нийлүүлэх, орон нутгийн өмчийн өгөөжийг нэмэгдүүлэн, ашигт ажиллагааг хангахад оршино. Компанийн дүрэмд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг гурил, малын тэжээл үйлдвэрлэх гэж тодорхойлжээ.

Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд хязгаарлагдмал хариуцлагатай компани статустай байна. Өмчийн 100 хувийг төр эзэмшиж байна.

3.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин

ӨВ агро гурил тэжээлийн үйлдвэр ХХК нь Өвөрхангай аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2021 оны 2-р сарын 9-ны 15 тоот тогтоолыг үндэслэн байгуулсан байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлд “Засгийн газар нь төрийн өмчийн бүрэн бүтэн байдлыг Улсын Их Хурлын өмнө хариуцах бөгөөд энэ талаар дараах бүрэн эрхтэй: ... 5/ хуульд өөрөөр заагаагүй бол төрийн өмчит хуулийн этгээдийг байгуулах,

өөрчлөх, татан буулгах тухай шийдвэр гаргах, түүний дүрмийг батлах;...” гэсэн заалттай нийцэж байна.

Засгийн газрын 2021 оны 43 дугаар “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” тогтоолын 1.3. “Төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, орон тоо, чиг үүргийн давхардлыг арилгаж, төсөв, зардлыг хэмнэсэн байхаар шинэчлэх, удирдлагын цалин хөлсийг орлого, үр ашигтай нь уялдуулан, үйл ажиллагааны чиглэл, цар хүрээ, түвшин зэргийг харгалзан нэг хэлбэр, нийтлэг жишгээр ангилан тогтоодог зарчимд шилжих, цалин хөлсийг нэмэгдүүлэхгүй, шагнал, урамшуулал олгохгүй байх, зочин төлөөлөгч хүлээн авах, бэлэг дурсгал (цүнх, календарь, мэндчилгээ г.м)-ын зардлыг гаргахгүй байх;”-д заасны дагуу ажиллаж зөрчил гаргаагүй байна

3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого

“ӨВ агро гурил тэжээлийн үйлдвэр” ОНӨ ХХК-ийн тайлангууд нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэгдсэн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0	13964.8	13964.8
БХХО			
Авлага		61764.0	61764.0
Урьдчилгаа			
Бараа материал		87428.4	57428.4
Үндсэн хөрөнгө		92593.6	92593.6
Биет бус хөрөнгө			
Нийт хөрөнгийн дүн		255750.8	255750.8
Өр төлбөрийн дүн		79004.7	79004.7
Богино хугацаат өглөг		79004.7	79004.7
Урт хугацаат өглөг			
Эздийн өмч		176746.1	176746.1
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн		255750.8	255750.8

Банк дахь мөнгөний үлдэгдэлд харилцах дансанд байгаа 13.9 сая төгрөг байна.

Авлагын үлдэгдэл аймгийн сумдад гэрээгээр нийлүүлсэн өвсний үнэ 61.8 сая төгрөг хугацаандаа байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 87.4 сая төгрөг байгаагаас борлуулаагүй өвсний үнэ 50.2 сая төгрөг байна

Тайлант онд худалдан авалтаар 19.5 сая төгрөгийн тээврийн хэрэгсэл 0.5 сая төгрөгийн тоног төхөөрөмж үнэ төлбөргүй хүлээн авсан, 38.0 сая төгрөгийн тээврийн хэрэгсэл ,40.8 сая төгрөгийн тоног төхөөрөмж гэрээ хийж зээлээр авсан байна.

Богино хугацаат өр төлбөр дансны үлдэгдэл 79.0 сая төгрөгийн өр төлбөр байгаагаас ААНОА татварын өр 0.2 сая төгрөг, зээлээр авсан тоног төхөөрөмж тээврийн хэрэгслийн үнэ 78.8 сая төгрөг байна.

Санхүүгийн тайланд зардал өртгийн талаарх мэдээллийг бэлтгэх зорилгын дагуу үйлдвэрлэсэн болон борлуулсан бүтээгдэхүүний өртөг, үйл ажиллагааны зардал гэж ангилсан байна.

Үйлдвэрлэсэн болон борлуулсан бүтээгдэхүүний өртөгт 181.1 сая төгрөгийн зардлуудыг хамруулсан нь өртөгт хуваарилагдах зардлууд байна.

3.4. Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу байгууллагын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

“ӨВ агро гурил тэжээлийн үйлдвэр” ОНӨ ХХК-ийн төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 04-р сарын 27-ны өдрийн 01 –р тогтоолоор бүтэц орон тоог баталсан байна. Бүтэц орон тоог 6, төсвийг Аймгийн ИТХ-н 8 удаагийн шийдвэрээр 136.3 сая төгрөгөөр баталсан байна. Орлогын эх үүсвэрийг төсвөөс 136.3 сая, өөрийн үйл ажиллагааны орлогоос 151.4 сая, төгрөгөөр тус тус бүрдүүлж 130.8 сая төгрөгийн өртөг бүхий өвс борлуулж, орлогын татварын зардал 0.2 сая төгрөг, татварын дараах ашиг 156.7 сая төгрөг байна

4. Аудитын тайлан

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Өвөрхангай аймгийн “ӨВ агро гурил тэжээлийн үйлдвэр” ОНӨ ХХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан дүгнэлтийг захирал Р.Намгилрагчаа танд танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд Шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг аудитор П.Сосорбурам гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Д.Гансүх, газрын дарга, тэргүүлэх аудитор О.Батжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Тус байгууллага нь 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Өвөрхангай аймаг дахь Төрийн аудитын газарт 3-р сарын 01-ны өдрийн 03 тоот бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Дотоод хяналт

Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд Аж ахуйн тооцоот үйлдвэрийг газар гэсэн статустай байна. Тус газар нь өөрт олгогдсон эд хөрөнгийн үндсэн дээр төсвийн хөрөнгөөр санхүүжиж, 100 хувь орон нутгийн өмч эзэмшиж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

ӨВ агро гурил тэжээлийн үйлдвэр ОНӨ ХХК нь дотоод хяналтын нэгж байгуулаагүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

4.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Өвөрхангай аймгийн "ӨВ агро гурил тэжээлийн үйлдвэр" ОНӨ ХХК-ийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

Өвөрхангай аймгийн "ӨВ агро гурил тэжээлийн үйлдвэр" ОНӨ ХХК-ийн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. Хүнсний материал худалдан авсан 3475.7 мянган төгрөгийг бараа материалын тайлан гаргаж, орлого авч зарлага гаргаагүй шууд үйлдвэрлэлийн зардлын дансанд бичсэн байна.
2. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг байгууллагынхаа онцлогт тохируулан боловсруулж баталж мөрдөөгүй байна

Дээрх зөрчлүүд нь

Нягтлан бодох бүртгэлийн хуулийн 13.7-д Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно: 13.4.т " Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна. 13.5-д Анхан шатны баримтад түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн буюу шалгасан ажилтан гарын үсэг зурж, тамга, тэмдэг дарснаар уг баримт хүчин төгөлдөр болно. Цахим хэлбэрээр бүрдүүлсэн анхан шатны баримт нь цахим гарын үсгээр баталгаажсан байна.18.2-т Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: 1 Албан шаардлага, 1 зөвлөмж хүргүүлэх.

4.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь нийт зардлын үзүүлэлтээр сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны 12 дугаар сарын 31-ны байдлаар 181.2 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 2.7 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 2.0 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

5.1 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай гэж заасны дагуу тус компани нь 2021 оны 4-р сард байгуулагдсан боловч, хуулийн дагуу шилэн дансны сайтад бүртгэл үүсгээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэх.

5.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 16 дугаар зүйлийн 16.5.5, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7, 20 дугаар зүйлийн 20.1.4 дэх заалтуудад тус тус нийцсэн байна гэж дүгнэлээ.

6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Тайлант онд завсрын аудит хийгдээгүй байна. Мөн 2021 онд үүсгэн байгуулагдсан учир санхүүгийн тайлангийн аудитад хамрагдаагүй байна.

7. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Нягтлан бодох бүртгэлийн хуулийг бүрэн хэрэгжүүлж, Анхан шатны бүртгэл хөтлөлт болон санхүүгийн тайлангийн уялдааг хангах

8. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 3.5 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 3.5 сая төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлж байна

8.1 Залруулсан алдаа

Байхгүй болно.

8.2 Төлбөрийн акт

Байхгүй болно.

8.3 Албан шаардлага

Нийт 2 албан шаардлага хүргүүлэх

8.4 Зөвлөмж

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг байгууллагынхаа онцлогт тохируулан боловсруулж, батлуулан мөрдөж ажиллах гэсэн 1 зөвлөмж хүргүүлэх

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/


Д/Д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал											
		2	3.5	0	0	0	0	1	3.5	1	0
	Дүн	2	3.5					1	3.5	1	
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал											
		1						1			
	Дүн	1						1			
	Нийт дүн	3	3.5					2	3.5	1	0

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  О. БАТЖАРГАЛ

АУДИТЫН МЕНЕЖЕР  Д. ГАНСҮХ

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР  П. СОСОРБУРАМ

2022 ОНЫ 03 ДУГААР САРЫН 15-НЫ ӨДӨР